

## ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ

/2016 оны 8-р сарын 24-нөөс 2016 оны 9-р сарын 21-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	VIII/24	VIII/31	IX/07	IX/14	IX/21
1	Гурил, I зэрэг, кг	1200	1200	1200	1200	1200
2	Хонины мах, кг/ ястай/	5800	5500	5500	5500	5500
3	Үхрийн мах, кг /ястай/	7000	7000	6500	7000	7000
4	Ямааны мах /ястай /	4800	5000	4500	4500	4500
5	Элсэн чихэр, кг	2100	2100	2200	2200	2200
6	Цагаан будаа, кг	2200	2200	2200	2200	2200
7	Шингэн сүү, л	900	900	900	1000	1000
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
9	- Бор ноолуур	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
10	Бензин, А-80, 1 литр	1470	1420	1420	1420	1420
11	Бензин, А-92, 1 литр	1530	1470	1470	1470	1470
12	Дизелийн түлш, 1 литр	1630	1550	1550	1550	1550

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2016 оны 8-р сарын 24-нөөс 2016 оны 9-р сарын 21-ны хооронд хонь, ямаа, үхрийн ястай мах, элсэн чихэр, шингэн сүү, шатахууны үнэ өөрчлөгдөж, цагаан будаа, гурилны үнэ тогтвортой байв.

Энэ хугацаанд ноолуурын арилжаа хийсэнгүй.

**Махны үнэ.** Хонины мах 8-р сарын 31-ний өдөр өмнөх 7 хоногийн мөн үеэс 5.2 хувиар буурч 5500 төгрөгийн ханштай байсан бол 9-р сарын 7-нд ямааны мах 8-р сарын 31-ний ханшнаас 10 хувиар буурч 4500 төгрөг болов. Үхрийн ястай мах 9-р сарын 7-нд 6500 төгрөгийн ханштай байсан бол 9-р сарын 14-нд 7000 төгрөг боллоо.

**Гурил, элсэн чихэр, цагаан будаа.** Гурил, цагаан будааны үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байлаа. Элсэн чихрийн үнэ 9-р сарын 7-нд 8-р сарын 31-ны ханшаас 4.8 хувиар өсч 2200 төгрөг болов.

**Шингэн сүү.** Шингэн сүүний үнэ 9-р сарын 14-нд өмнөх 7 хоногийн мөн үеэс 11.1 хувь буюу 100 төгрөгөөр өсч 900 төгрөгийн дундаж ханштай байв.

**Шатахуун.** 8-р сарын 31-ний өдрийн мэдээгээр өмнөх 7 хоногийн мөн үеэс А-80 бензин 3.4 хувиар, А-92 3.9 хувиар, дизелийн түлш 4.9 хувиар тус тус буурч харгалзан 1420, 1470, 1550 төгрөгийн ханштай байв.

